

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК-ийн туслах аудитор: Г.Тунгалаг
Утас: 88082716, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

100

100

100

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

10

11

12

13

14

15



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-02-13 №УВН-2026/130/НА-СТН-ТШЗ
танай _____-ны № _____-т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б. БУЯНТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгин үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050330

PLA

U

U

U

U

U

PLA

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1-1-1

1-1-1

1-1-1

1-1-1

1-1-1

1-1-1

1-1-1

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	281,206,442.21	395,329,061.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	145,633,425.37	213,845,100.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	145,633,425.37	213,845,100.03
3121	Төгрөг	145,633,425.37	213,845,100.03
31211	Төрийн сангийн харилцах	145,633,425.37	213,845,100.03
33	АВЛАГА	720,480.00	24,610,471.33
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	720,480.00	00.00
335	Бусад авлага	00.00	24,610,471.33
3351	Байгууллагаас авах авлага	00.00	24,610,471.33
35	БАРАА МАТЕРИАЛ	134,852,536.84	156,873,489.84
351	Түүхий эд материал	16,805,672.61	26,082,605.61
35110	Тусгай зориулалттай материал	16,805,672.61	26,082,605.61
354	Хангамжийн материал	118,046,864.23	130,790,884.23
35410	Бичиг хэргийн материал	1,723,100.00	9,219,370.00
35420	Аж ахуйн материал	10,363,900.00	14,171,650.00
35470	Бусад хангамжийн материал	105,959,864.23	107,399,864.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,497,073,596.22	2,681,987,101.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,497,073,596.22	2,681,987,101.64
392	Биет хөрөнгө	1,746,733,596.22	1,931,707,101.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,502,458,955.00	1,502,458,955.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-159,898,970.12	-186,694,380.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,350,000.00	31,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,021,875.00	-18,940,625.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	624,339,254.80	758,333,831.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-386,344,782.00	-392,464,071.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	227,892,760.67	350,336,155.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-131,562,385.04	-166,193,401.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,705,900.00	9,705,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,705,900.00	-9,705,900.00
39217	Ном	53,520,637.91	53,520,637.91
393	Биет бус хөрөнгө	750,340,000.00	750,280,000.00
39301	Програм хангамж	2,850,000.00	2,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,730,000.00	-2,790,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	750,220,000.00	750,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,778,280,038.43	3,077,316,162.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,887,416.00	59,938,229.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,887,416.00	59,938,229.10
413	Өглөг	4887416.00	59938229.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,887,416.00	00.00

4136	Бусад өглөг	00.00	59,938,229.10
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	59,938,229.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,773,392,622.43	3,017,377,933.74
51	Засгийн газрын хувь оролцоо	2,773,392,622.43	3,017,377,933.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,368,870,237.65	1,368,870,237.65
51101	Өмч: - төрийн	1,368,870,237.65	1,368,870,237.65
512	Хуримтлагдсан үр дүн	1,176,183,435.12	1,420,168,746.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,176,183,435.12	1,176,183,435.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	243,985,311.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,338,949.66	228,338,949.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,778,280,038.43	3,077,316,162.84

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,604,799,883.50	4,451,837,408.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,884,283.50	206,051,908.92
120	Нийтлэг татварын бус орлого	33,884,283.50	206,051,908.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,836,553.00	41,673,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,836,553.00	24,413,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,160,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	15,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	3,570,915,600.00	4,245,785,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,288,753,200.00	3,994,524,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,288,753,200.00	3,994,524,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,518,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,518,800.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,162,400.00	247,742,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,162,400.00	247,742,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,580,382,839.56	4,207,852,097.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,580,382,839.56	4,207,852,097.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,523,766,149.59	3,957,742,783.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,529,231,724.26	3,066,766,336.22
210101	Үндсэн цалин	1,630,392,291.16	1,831,475,686.40
210102	Нэмэгдэл	734,824,253.10	946,759,849.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	88,552,000.00
210104	Урамшуулал	164,015,180.00	199,978,800.00

2

3


4

5

6

7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	314,238,701.19	382,349,207.81
210201	Тэтгэврийн даатгал	214,655,243.39	260,739,489.65
210202	Тэтгэмжийн даатгал	25,536,517.39	30,879,824.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,577,157.72	15,541,686.08
210204	Ажилгүйдлийн даатгал	12,309,259.54	14,834,844.10
210205	Эрүүл мэндийн даатгал	49,160,523.15	60,353,363.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,012,810.03	289,096,612.47
210301	Гэрэл, цахилгаан	15,801,532.09	22,087,986.03
210302	Түлш, халаалт	251,261,825.94	251,264,730.44
210303	Цэвэр, бохир ус	8,949,452.00	15,743,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,944,971.41	50,608,119.00
210401	Бичиг хэрэг	5,006,690.00	8,075,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,235,181.41	27,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,223,100.00	42,504,919.00
2105	Нормативт зардал	142,769,990.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	185,800.00	00.00
210502	Хоол, хүнс	142,584,190.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,530,000.00	7,198,000.00
210604	Урсгал засвар	4,530,000.00	7,198,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,502,560.00	210,000.00
210701	Гадаад албан томилолт	568,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	9,934,560.00	210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,660,661.57	41,262,059.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,589,100.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,145,911.57	41,229,059.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,874,731.13	120,252,448.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,044,717.97	31,345,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,084,118.00	17,382,482.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,745,895.16	71,524,466.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,616,689.97	250,109,313.63
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,467,100.00	235,844,817.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	223,293,617.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,467,100.00	12,551,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,149,589.97	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,149,589.97	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	14,264,496.63



213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	14,264,496.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,417,043.94	243,985,311.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	24,417,043.94	243,985,311.31

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,577,752,153.00	4,272,359,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,836,553.00	26,573,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,836,553.00	26,573,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,836,553.00	26,573,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,836,553.00	24,413,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,160,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,570,915,600.00	4,245,785,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,288,753,200.00	3,994,524,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,518,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,518,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,162,400.00	247,742,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,162,400.00	247,742,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,463,375,705.98	4,103,150,829.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,463,375,705.98	4,103,150,829.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,264,174,826.01	3,859,823,415.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,525,778,133.52	3,087,104,103.27
210101	Үндсэн цалин	1,626,938,700.42	1,853,623,271.53
210102	Нэмэгдэл	734,824,253.10	955,326,917.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	87,931,202.33
210104	Урамшуулал	164,015,180.00	190,222,711.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	313,419,493.51	390,138,958.75
210201	Тэтгэврийн даатгал	213,836,035.71	268,593,126.07
210202	Тэтгэмжийн даатгал	25,536,517.39	30,621,044.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,577,157.72	15,436,989.19
210204	Ажилгүйдлийн даатгал	12,309,259.54	15,134,435.03
210205	Эрүүл мэндийн даатгал	49,160,523.15	60,353,363.53
2103	Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал	276,012,810.03	226,279,703.37
210301	Гэрэл, цахилгаан	15,801,532.09	22,087,986.03

101

102


103

104

105

106

210302	Түлш, халаалт	251,261,825.94	188,447,821.34
210303	Цэвэр, бохир ус	8,949,452.00	15,743,896.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	7,198,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	7,198,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,735,011.57	41,569,059.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,589,100.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,145,911.57	41,569,059.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,229,377.38	107,533,590.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,629,177.38	88,906,408.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,600,200.00	18,627,182.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,200,879.97	243,327,413.63
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	198,051,290.00	229,062,917.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,584,190.00	216,511,717.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,467,100.00	12,551,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,149,589.97	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,149,589.97	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	14,264,496.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	14,264,496.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	114,376,447.02	169,208,470.66
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,288,753,200.00	3,994,524,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	91,740,360.00	100,996,796.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	91,740,360.00	100,996,796.00
2200	Дотоод эх үүсвэрээр	91,740,360.00	100,996,796.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	91,740,360.00	100,996,796.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-91,740,360.00	-100,996,796.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,288,753,200.00	3,994,524,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,636,087.02	68,211,674.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,997,338.35	145,633,425.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	145,633,425.37	213,845,100.03



2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	618,650,237.65	367,596,036.93	110,153,627.64	00.00	1,096,399,902.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	618,650,237.65	367,596,036.93	110,153,627.64	00.00	1,096,399,902.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-71,344,213.31	00.00	-71,344,213.31
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	1,176,183,435.12	00.00	2,773,392,622.43
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	1,176,183,435.12	00.00	2,773,392,622.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	1,176,183,435.12	00.00	2,773,392,622.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	00.00	00.00	00.00	00.00	00.00



	өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгү й олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлти йн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	243,985,311.31	00.00	243,985,311.31
D09	2025 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	1,420,168,746.43	00.00	3,017,377,933.74

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,231,896,900.00	3,956,405,425.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,231,896,900.00	3,956,405,425.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,989,724,000.00	3,727,342,508.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,262,093,600.00	3,085,162,443.86
210101	Үндсэн цалин	2,113,712,300.00	1,853,623,271.53
210102	Нэмэгдэл	976,477,400.00	953,385,258.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	87,931,202.33
210104	Урамшуулал	171,903,900.00	190,222,711.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	408,259,100.00	390,138,958.75
210201	Тэтгэврийн даатгал	277,652,600.00	268,593,126.07
210202	Тэтгэмжийн даатгал	32,651,600.00	30,621,044.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,325,800.00	15,436,989.19
210204	Ажилгүйдлийн даатгал	16,325,800.00	15,134,435.03
210205	Эрүүл мэндийн даатгал	65,303,300.00	60,353,363.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,900,600.00	53,303,059.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,950,300.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,950,300.00	53,303,059.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	207470700.00	198738045.75

1820

1821

1822

1823

1824

1825

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,493,600.00	181,015,013.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,977,100.00	17,723,032.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	242172900.00	229062917.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	242,172,900.00	229,062,917.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	229,621,700.00	216,511,717.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,551,200.00	12,551,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,175,946,500.00	4,024,617,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,006,888,100.00	3,994,524,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,006,888,100.00	3,994,524,500.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	169,058,400.00	26,573,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,187,400.00	24,413,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,756,800.00	2,160,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	144,114,200.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	145,633,425.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	213,845,100.03
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	92.00	92.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	75.00	75.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
				Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	247,742,200.00	233,477,703.37	14,264,496.63	94.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	247,742,200.00	233,477,703.37	14,264,496.63	94.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,742,200.00	233,477,703.37	14,264,496.63	94.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	240,542,200.00	226,279,703.37	14,262,496.63	94.1%
210301	Гэрэл цахилгаан	20,064,000.00	22,087,986.03	-2,023,986.03	110.1%
210302	Түлш, халаалт	193,976,300.00	188,447,821.34	5,528,478.66	97.1%

110

111

112

113

114

115

210303	Цэвэр, бохир ус	26,501,900.00	15,743,896.00	10,758,004.00	59.4%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,200,000.00	7,198,000.00	2,000.00	100%
210604	Урсгал засвар	7,200,000.00	7,198,000.00	2,000.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	247,742,200.00	247,742,200.00		100%
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	247,742,200.00	247,742,200.00		100%
132001	Орон нутгийн төсвөөс	247,742,200.00	247,742,200.00		100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	92.00	92.00		100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	75.00	75.00		100%
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, сурацахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдарын зохих чадвартай, хүмүүлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн



- ✓ Төрийн албаны тухай хуульд -2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр, түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалда авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 299,036.2 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	145,633.4	213,845.1	68,211.7
Авлага	720.5	24,610.5	23,890.0

11
12
13
14
15
16
17
18
19
20
21
22
23
24
25
26
27
28
29
30
31
32
33
34
35
36
37
38
39
40
41
42
43
44
45
46
47
48
49
50
51
52
53
54
55
56
57
58
59
60
61
62
63
64
65
66
67
68
69
70
71
72
73
74
75
76
77
78
79
80
81
82
83
84
85
86
87
88
89
90
91
92
93
94
95
96
97
98
99
100

Бараа материал	134,852.5	156,873.5	22,021.1
Үндсэн хөрөнгө	2,497,073.6	2,681,987.1	184,913.5
Нийт хөрөнгө	2,778,280.0	3,077,316.2	299,036.2
Өр төлбөр	4,887.4	59,938.2	55,050.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,773,392.6	3,017,377.9	243,985.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,778,280.0	3,077,316.2	299,036.2

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 68,211.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага данс нь 23,890.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлснөөс үүсчээ.

Бараа материал дансны үлдэгдэл 156,873.5 мянган төгрөг болж 22,021.1 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын ерөнхий газраас үнэгүй ирсэн сурах бичгийг дансанд тусгажээ. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,681,987.1 мянган төгрөг болж, 184,913.5 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын ерөнхий газар, Мобиком ххк-с үнэ төлбөргүй хөрөнгө авсан байна.

Өр төлбөр данс 59,938.2 мянган төгрөгөөр өссөн нь түлш, халаалтын зардал болон бичиг хэргийн зардалд өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,017,377.9 мянган төгрөг болж 243,985.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт


Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,529,938.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 949,700.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,994,525.5 мянга, орон нутгийн төсвөөс 247,742.5 мянга, нийт 4,242,268.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,994,524.5 мянга, өмнөх оны үлдэгдлээс 144,114.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,413.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,160.0, мянга, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 3,518.8 мянга, нийт 4,168,731.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж урсгал үйл ажиллагааны зардалд 3,956,405.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд оны эхний үлдэглээс 1,519.2 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.



Орон нутгийн төсвөөс 233,477.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж гэрэл цахилгааны зардалд 22,088.0 мянга, түлш халаалтын заралд 188,447.8 мянган, цэвэр, бохир усны зардалд 15,743.9 мяна, урсгал засварын зардалд 7,198.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,189,883.1 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 176,931.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 18,120.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 8,732.6 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 13,109.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл


/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	5,003.7	4,962.9	40.8	99%
2	Сургалт семинар /80312/	2,755.9	2,747.3	8.6	99%
3	Эрүүл мэндийг дэмжих /81605/	5,275.0	5,275.0	0.0	100%
4	Үдийн цай /81801/	217,258.1	216,511.7	7,463.8	98%
5	Ерөнхий болвсрол ,хүүхэд хамгаалал/ 80233/	5,146.8	4,821.5	325.2	94%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин/81816/	92,452.2	92,347.3	104.8	99%
7	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх /81823//	16,483.5	14,577.3	1,906.2	88%
8	Боловсролын стандарт сургалтын /81834/	3,568,065.8	3,442,020.2	126,045.5	96%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	206,210.7	137,814.8	68,395.8	67%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж		-	Байгууллагын үйл ажиллагаанд 2,850.0 мянган төгрөгийн программ ашиглаж байна.
2	Унаа,хоолны зардал		88,552.0	2025 онд унаа, хоолны зардалын төсөв гэж төсөвлөөгүй бөгөөд цалингийн зардалаас 88,552.0 мянган төгрөг олгосон.
3	Сургалт ,семинар	-	-	Тухайн сургуульд төсөвлөгдсөн зардал байхгүй



4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	1,800.0	Тайлант жилд хэвлэл мэдээллийн байгууллага МБСТВ ххк-тай гэрээ байгуулж 1,800.0 төлбөр төлсөн.
7	Орон тоо	3,262,093.6	3,085,162.4	Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2025 онд 97 орон тоотой үйл ажиллагаа явуулж 3,262,093.6 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 3,085,162.4 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс, урамшуулалд зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сурнууль нь хүүхдийн үдийн хоолны шууд худалдан авалтыг 4 багц бүтээгдэхүүнд 229,621.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр tender.gov.mn цахим хуудсанд байршуулан худалдан авалтыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

12

13

14

15

16

17

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Г.Тунгалаг гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,298,220.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,982.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,207,852.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 42,078.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 33,662.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.


Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,



нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 163, хугацаа хоцроож 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 912.0 мянган төгрөгийн зөрчил зөвлөмж, 712.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг биелэлтийг бүрэн хангаж 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 249,356.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 249,356.4 мянган төгрөгийн алддааг залруулж баталгаажуулав.

Залруулсан алдаа:

1. **Мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг зөрчин мөнгөн гүйлгээний тайланд 1,614.2 мянган төгрөгийн орлогыг дутуу тусгасныг залрууллаа.
2. **Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой :** Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана" гэж заасныг зөрчин төсвийн гүйцэтгэлийн тайланд 247,742.2 мянган төгрөгийн төсвийн төлөвлөгөөг тусгаагүй байсныг залрууллаа.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс	Зөвлөмж
-------------------	------------	------------	--------------------------	--------	---------

/мянган төгрөгөөр/

4

26

31

31

31

31

			тусгахгүй орхигдуулсан				Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд 1,614.2 мянган төгрөгийн орлогыг дутуу илэрхийлсэн	1	1,614.2					1	1,614.2				
Төсийн гүйцэтгэлийн тайланд 247,742.2 мянган төгрөгийн төлөлөгөөг дутуу тусгасан	1	247,742.2					1	247,742.2				
Дүн	2	249,356.4					2	249,356.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ТУСЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.ТУНГАЛАГ/

2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

100
100

100

100

100